

СОЁЛ, УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС 2023 ОНД НИЙТ 19 ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНД САНХҮҮЖИЛТ ОЛГОХООР ШИЙДВЭРЛЭЛЭЭ.

Засгийн газрын 2020 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын хүрээнд Соёл урлагийг дэмжих сангаас 2023 онд санхүүжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2023 оны 03 дугаар сарын 17–ны өдрөөс 04 дүгээр сарын 18-ны өдрийн хооронд олон нийтэд нээлттэй зарлаж тус сангийн цахим системээр нийт 375 төслийн материал бүртгэгдсэн.

Соёл, урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн эхний хурал 2023 оны 05 дугаар сарын 05–06-ны өдрүүдэд зохион байгуулагдаж цахим системд бүртгэгдсэн нийт төсөлд (a) Төсөлд үнэлгээ хийх боломжтой эсэх, (b) төслийн иж бүрдлийн үнэлгээ (c) төсөлд тавигдах шаардлага, төслийн ач холбогдлын үнэлгээ гэсэн гурван шалгуур үзүүлэлтийн хүрээнд дүгнэж нийт 90 төсөл, арга хэмжээг дараагийн шатны шалгаруулалт буюу илүү нарийвчилсан байдлаар дүгнэх шийдвэрийг гарган Соёлын яамны www.moc.gov.mn цахим сайтад 2023 оны 05 дугаар сарын 08-ны өдөр байршуулж олон нийтэд мэдээлсэн.

Сүүлийн шатанд шалгарсан 90 төслийн баг 2023 оны 05 дугаар сарын 12–14-ний өдрүүдэд МҮОНТ (600 студи)–ийн байранд ажлын хэсгийн гишүүдэд төслийн дэлгэрэнгүй танилцуулгыг хийсэн бөгөөд төслийн танилцуулах явц, дэлгэрэнгүй мэдээлэл бүхий “Монгол соёл – Монголын баялаг” нэртэй 10 цуврал нэвтрүүлэг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 07 дугаар сарын 09-ний хооронд бямба, ням гарагуудад МҮОНТ–ээр үзэгчдийн хүртээл боллоо.

Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний саналыг хэлэлцэн дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хуралдаан зохион байгуулагдаж сүүлийн шатны шалгаруулалтад оролцсон 90 төсөл тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэл, телевизийн бичлэгтэй нэг бүрчлэн танилцаж төсөл тус бүрд (i) төрийн бодлого хөтөлбөртэй уялдаж байгаа эсэх, (ii) хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь тодорхой эсэх, (iii) төслийн хамрах хүрээ, (iv) бүтээлч, шинэлэг байдал, (v) төсөл хэрэгжсэнээр нийгэм, хувь хүнд үзүүлэх нөлөөлөл, (vi) эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж, (vii) төслийн ач холбогдол, цаг үетэйгээ нийцэж байгаа эсэх, (viii) төсөл хэрэгжүүлэгч талын туршлага, (ix) хэрэгжүүлэх ажлын болон санхүүгийн төлөвлөгөө, тооцоолол, (x) ач холбогдол урьдчилсан үр дүнгийн төсөөллийг гаргасан эсэх гэсэн шалгуур үзүүлэлтийг үндэслэн дүгнэлт гаргаж “Соёл, урлагийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ын 3.6-д заасны дагуу Соёлын сайдад танилцуулсан.

Уг дүгнэлтийг үндэслэн Соёлын сайдын 2023 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/282 дугаар бүхий “Соёл урлагийг дэмжих сангаас санхүүжүүлэх төсөл,

арга хэмжээ, санхүүжилт батлах тухай” тушаал гарч дараах нэр бүхий 19 төсөлд 651,602,700 /зургаан зуун тавин нэгэн сая зургаан зуун хоёр мянга долоон зуу/ төгрөгийн санхүүжилт олгохоор шийдвэрлэв.

СОЁЛ УРЛАГИЙГ ДЭМЖИХ САНГААС 2023 ОНД САНХҮҮЖҮҮЛЭХ
ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Төсөл, арга хэмжээний нэр:	Хэрэгжүүлэгч байгууллага, иргэний нэр:
1	Керамикийн уран бүтээлчдийн туршлага солилцох, урлагийн төрлийн хувьд сурталчлан таниулах	Гунанбат овогтой Ганбаатар
2	Эртний уран зохиол	Бат-Очир овогтой Чанагнянгар
3	Алтан огтлол	Сэрээтэр овогтой Дагвадорж
4	Дөрвөдийн баатарлаг туулийг шавь сургалтаар дамжуулан өвлүүлэн уламжлуулах	Идэш овогтой Төгсөө
5	Өвгөн шувуу хоёр	Нямдугар овогтой Азжаргал
6	Аялгуут өв	Даваажамц овогтой Сандуй
7	Монголын үндэстэн, ястны ардын богино 1008 дуу	Хатагин овогт Шагдарын Даваахүү сан
8	Цогт Хунтайжийн Монгол нутаг дахь түүх, бичиг соёлын дурсгалын танилцуулга, сурталчилгааг виртуал технологи ашиглан хэрэгжүүлэх	“Цогт тайжийн өргөө орд” сан
9	“Баруун Монголын Нүүдэлчин соёлын ялгаатай байдал” контент бүтээх	Хөдөөний айл Есч НҮТББ
10	Хилийн чанадад буй Монгол соёлын өвийн цахим мэдээллийн сан бүрдүүлэх нь	Соёлын өвийн сүлжээ, харилцаа холбооны зөвлөл НҮТББ
11	Үндэсний бичгийн зуун	Асу медиа видео сайт ХХК
12	"Дэлхийн өв: Монгол уртын дуу"	"Монголын уртын дууны холбоо" НҮТББ
13	Хүүхэд насанд хүргэж өгдөг галт тэрэг	Хөгжмийн зохиолч Л.Галмандах сан
14	Монгол Романс	Дуурийн Урлаг сан
15	Монгол язгуур урлагийг орчин үеийн технологитой хослуулсан “Орижинс”	Тэнгри Менежмент Партнерс ХХК
16	Монгол хөгжим XXI	Анир Саунд Рекордс ХХК
17	"Өгүүлэхүйн эрхтэний шүтэлцээт урлаг"	Монгол хөөмэйн хүн хөгжим сан
18	Бор зааны аялал	Богдын хүүхдүүд хоршоо
19	"Монголын сайхан орон" баримтат киноны хөгжмийн пянзны эх бэлтгэх	Монголын Их Найрал Хөгжмийг дэмжигчдийн холбоо НҮТББ

Жич: Шалгарсан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллага, иргэнтэй Соёл, урлагийг дэмжих сангийн ажлын хэсгээс холбогдоно.

---oOo---